


## Ипотекийн зээлийн тайлан

2015 оны 1 дүгээр сар


Банкууд 2015 оны 1 дүгээр сард нийт 1280 зээлдэгчид 75.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 2898.8<sup>1</sup> тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 67233-т хүрчээ.

Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 3.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 92.6 нэгж хувиар буурсан байна.




Банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” (ОСИСТТБХ)-ийн хэрэгжилттэй холбоотойгоор 2013 оноос эхлэн эрс нэмэгдсэн байна.

**Ипотекийн зээлийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь**



Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 71.5 хувь буюу 2073.0 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 26.1 хувь буюу 756.7 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 2.4 хувь буюу 69.2 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.

**Ипотекийн зээлийн үлдэгдэл, эх үүсвэрээр**



<sup>1</sup> МИК-т шилжүүлсэн зээлийн дүн орсноор.

2015 оны 1 дүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.1 хувь нь төгрөгийн зээл, 1.9 хувь нь гадаад валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2015 оны 1 дүгээр сарын байдлаар 2.1 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 0.5 байна.



### Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 30.9 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.1 хувиар буурсан байна.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 68.9 хувь буюу 51.7 тэрбум төгрөг нь “Орон

сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 30.6 хувь буюу 22.9 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.

Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2015 оны 1 дүгээр сарын байдлаар 58.6 сая төгрөг байна.



Тухайн сард 22.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх сараас 14.5 хувиар буурсан ч өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар өссөн байна.




### Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1280 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 918 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 352 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд, 10 зээлдэгч бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



2015 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 67233 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 46134 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 19084 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 2015 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.

### Нийт зээлдэгчдийн тоо болон сарын өсөлт




### Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 0.5-20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 16.3 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2015 оны 1 дүгээр сарын байдлаар 15.3 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 50.2 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 61.6 хувь нь 16-20 жил, 22.8 хувь нь 11-15 жил, 12.8 хувь нь 6-10 жил, 2.7 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.

### Ипотекийн зээл, хугацааны ангиллаар



## Зээлийн хүү

Банкуудын 2015 оны 1 дүгээр сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 10.2 хувь байв. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 6.4 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.2 хувь байв.

## Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (сараар)	Тухайн сард олгосон зээлийн ЖДХүү, жилээр (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:		
			ОСИСТБ хөтөлбөрийн зээл				ОСИСТБ хөтөлбөрийн зээлтэй		
2008	12	217,977.5		100.7	19.8	16,522			
2009	12	226,040.6		103.4	18.7	16,784			
2010	12	333,776.6		115	16	19,700			
2011	12	669,662.8		154.3	14.8	26,869			
2012	12	845,204.4		155.5	15.3	29,887			
2013	1	856,633.6		149.1	17	29,683			
	2	873,666.4		156.1	16.8	29,946			
	3	903,557.5		158.6	15.7	30,419			
	4	944,516.8		155.4	15.8	31,412			
	5	986,182.2		147.8	16.6	32,247			
	6	1,032,156.7		276,328.4	168.3	12.9		33,028	9,670
	7	1,273,003.6		553,346.9	202.4	9.2		37,751	17,202
	8	1,461,753.4	781,483.2	207.6	8.9	40,596	21,832		
	9	1,611,383.8	943,976.7	206	9.1	42,968	24,851		
	10	1,750,781.6	1,076,924.5	193.9	9.6	45,138	27,302		
	11	1,834,042.7	1,155,409.2	192.8	9.7	46,482	28,749		
	12	1,938,945.3	1,248,633.8	192.8	9.9	48,320	30,600		
2014	1	2,021,424.9	1,324,898.9	194.4	9.8	49,731	32,190		
	2	2,121,802.6	1,382,084.1	193.2	9.9	53,611	33,346		
	3	2,193,368.6	1,451,938.1	190.7	9.9	54,787	34,632		
	4	2,280,503.5	1,538,506.8	192.1	9.8	56,137	36,081		
	5	2,365,349.5	1,618,127.2	189.3	10	57,579	37,488		
	6	2,440,007.1	1,684,583.9	182.3	10.5	58,793	38,659		
	7	2,492,105.2	1,728,222.8	187.9	10.7	59,756	39,507		
	8	2,553,827.2	1,780,078.3	186.7	10.5	60,851	40,405		
	9	2,619,161.1	1,833,494.0	185.9	10.6	62,017	41,390		
	10	2,703,792.6	1,903,636.6	189.3	10.4	63,652	42,772		
	11	2,762,633.1	1,954,247.6	194.5	10.3	64,577	43,621		
	12	2,844,612.6	2,027,859.2	200.1	9.9	66,334	45,283		
2015	1	2,898,836.5	2,073,000.1	195.9	10.2	67,233	46,134		

## Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2014 оны 12 дугаар сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХугацаа (сар)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБХ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	2,191,347.2	77.0%	1,525,380.0	75.2%	201.4	10.1	44695	38,872
2 Дархан-Уул	102,464.5	3.6%	86,858.3	4.3%	205.4	9.6	3147	895
3 Орхон	97,133.1	3.4%	82,226.4	4.1%	194.9	9.5	2667	856
4 Дорноговь	58,687.5	2.1%	46,053.3	2.3%	200.9	9.1	1757	570
5 Сэлэнгэ	40,730.9	1.4%	31,614.0	1.6%	203.3	8.2	1425	406
6 Дорнод	37,510.5	1.3%	33,462.4	1.7%	198.0	8.2	1290	371
7 Өвөрхангай	36,711.4	1.3%	25,131.8	1.2%	202.0	8.2	1347	354
8 Увс	34,445.1	1.2%	23,435.2	1.2%	208.4	9.1	1220	288
9 Өмнөговь	32,550.2	1.1%	22,198.7	1.1%	199.0	11.0	928	284
10 Баянхонгор	32,203.0	1.1%	28,408.2	1.4%	209.3	8.9	965	486
11 Ховд	26,072.7	0.9%	21,076.6	1.0%	199.6	8.9	943	395
12 Баян-Өлгий	19,168.5	0.7%	9,175.8	0.5%	185.3	8.0	994	121
13 Сүхбаатар	18,379.9	0.6%	11,637.4	0.6%	164.8	11.2	710	198
14 Архангай	17,887.7	0.6%	13,584.7	0.7%	190.5	8.3	568	208
15 Говь-Алтай	16,306.2	0.6%	12,851.6	0.6%	168.2	10.6	556	227
16 Завхан	14,579.9	0.5%	8,621.3	0.4%	192.2	8.8	599	132
17 Хөвсгөл	14,531.0	0.5%	6,891.6	0.3%	157.4	10.5	638	82
18 Дундговь	11,592.5	0.4%	9,009.5	0.4%	188.3	10.6	370	155
19 Төв	11,439.1	0.4%	7,978.1	0.4%	172.7	11.6	391	80
20 Говьсүмбэр	10,876.2	0.4%	9,819.4	0.5%	208.5	8.5	370	105
21 Булган	10,219.8	0.4%	5,117.3	0.3%	137.0	13.1	398	69
22 Хэнтий	9,775.7	0.3%	7,327.6	0.4%	211.5	9.3	356	129
<b>Нийт</b>	<b>2,844,612.6</b>	<b>100%</b>	<b>2,027,859.2</b>	<b>100%</b>	<b>200.1</b>	<b>9.9</b>	<b>66334</b>	<b>45283</b>

2014 оны 12 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.0 хувийг Улаанбаатар хотод, 23.0 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 15.7 хувь буюу 102.5 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 14.9 хувь буюу 97.1 тэрбум төгрөг Орхон аймагт, 9.0 хувь буюу 58.7 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.